

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалыа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- ✓ төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- ✓ Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- ✓ Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх

Бүрдүүлэх материал:

- ✓ Төрийн албан хаагчийн анкет;
- ✓ Иргэний үнэмлэхийн хуулбар;
- ✓ Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуултыг хавсаргах;
- ✓ Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- ✓ Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- ✓ Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- ✓ Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- ✓ Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- ✓ Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/

Материал хүлээн авах:

- ✓ Хугацаа: 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 17.00 цаг хүртэл

Хүлээн авах хаяг:

- ✓ info@dundgovi.gov.mn

ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					Төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
Зарласан байгууллага: Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар Шилжих, сэлгэн ажиллах санал ирүүлэх хаяг: info@dundgovi.gov.mn Холбоо барих утас: 70592548, 70592362										
1	Эрүүл мэндийн газар	-	Дарга	1	Удирдах	T3-5	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	-Эрүүл мэнд -Хүний их эмч -Нийгмийн эрүүл мэнд	-Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх	-Төрийн албанд 6-аас доoshгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доoshгүй жил ажилласан байх
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Дарга	1	Удирдах	T3-4	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	-Менежмент ба удирдахуй /0413/ -Эдийн засаг /0311/ -Эрх зүй /042/ -Хэл /023/ -Орон судлал /022203/ -Боловсрол /011/ -Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй /03/ -Мэдээлэл, харилцаа, холбооны технологиуд /061/ -Улс тэр, иргэн судлал /0312/ -Олон нийттэй харилцах ажил /041402/ -Нийгмийн хамгаалал /092/ -Бусад	-Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх	-Төрийн албанд 6-аас доoshгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доoshгүй жил ажилласан байх